

ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Геронтологийн үндэсний төв

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, тэдний гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах	Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан хүний тоо	1.Төвийн нийт ажилтнуудыг 2025 оны 03, 04 сард өөрийн эмнэлэг дээрээ урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үүнд: ➤ Зүрх судас /ЭКГ/ ➤ Дотор /Хэвлийн ЭХО/ ➤ Мэдрэл /Дуплекс/ ➤ Үений ЭХО ➤ Ясны сийрэгжилт ➤ Сахар ➤ Биеийн жингийн индекс тодорхойлох зэрэг үзлэг, оношлогоонд тус тус хамруулсан. 2. Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, тэдний гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг V/10-VI/10-нд төвийнхөө нөөц бололцоонд тулгуурлан зохион байгууллаа. Үүнд: ➤ Дотор, мэдрэл, уламжлалт, сэргээн засах, нүдний эмчийн үзлэг ➤ Хэвлийн ЭХО, үений ЭХО, тархины судасны дуплекс, ясны сийрэгжилт, бие бялдарын цогц үнэлгээний аппарат, өлөн үеийн цусанд сахар тодорхойлох шинжилгээнүүдэд хамрагдсан. Үзлэг шинжилгээнд 37-75 насны 15 хүн хамрагдснаас хоол боловсруулах зам, бөөр шээсний замын өвчлөл, нүдний хуурайшилт, ойрын харааны өөрчлөлт, өвдөгний үений остеоартрит, жингийн илүүдэл, ясны нягтрал буурсан зэрэг өөрчлөлтүүд дийлэнхи хувийг эзэлж байна.
2	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын онцлог, ололт амжилтыг олон нийтэд сурталчилан таниулах, соён гэгээрүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Геронтологийн үндэсний төвийн эмч мэргэжилтэн ажилтнуудын дунд эрдмийн зэрэг цол хамгаалсан олон эмч мэргэжилтнүүд ажиллаж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын онцлог, ололт амжилтыг сурталчлах ажлыг зохион байгуулж 2025. 05.17-ны өдөр Геронтологийн үндэсний төвд настны эмчээр ажиллаж байсан Ч.Одгэрэл, сувилагчаар ажиллаж байсан

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
	арга хэмжээг зохион байгуулах		Л.Одгэрэл нар Анагаах ухааны докторын зэргээ хамгаалсаныг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулсан.
3	Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа амь насаа алдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүндэтгэл үзүүлэхийг жил бүрийн 3 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулах	Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа амь насаа алдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Геронтологийн үндэсний төвөөс ажил үүргээ гүйцэтгэх явцдаа амь насаа алдсан эмч эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад мэргэжилтэн, туслах ажилтан байхгүй байна.
4	Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад настуудад хүндэтгэл үзүүлэх, тэднийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах	Өдөрлөг уулзалтын тоо, хамрагдсан хүний тоо Урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд хамруулсан хүний тоо	1.Геронтологийн үндэсний төв үүсгэн байгуулагдснаас хойших үе үеийн ахмад настуудад хүндэтгэл үзүүлж, ахмад настан болон залуу ажилчдын дунд 4 төрөлт спортын наадмыг 2025.05.17 оны өдөр зохион байгуулсан. Тус тэмцээнд 2005-2025 он хүртэлх хугацаанд ажиллаж байсан нийт ажилчдын төлөөлөл 100 гаруй тамирчид 5 багт хуваагдан оролцож сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, дартс гэсэн төрлүүдээр авхаалж самбаа, хүч чадлаа дайчлан өрсөлдлөө. Тэмцээнд хүрэлцэн ирсэн Геронтологийн үндэсний төвийн үе үеийн захирлууд болох Г. Шүрэнцэцэг, Р. Оюунханд, М. Нямсүрэн, Р. Хишигжаргал нар Үе үеийн ахмад ажилтан болон одоо ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийт ажилтнуудад талархал илэрхийлсэн. Тэмцээний сагсан бөмбөгийн төрөлд тэргүүн байр Геронтологийн акулууд баг, дэд байр Морьтон баг, гутгаар байранд Залуус баг Гар бөмбөгийн төрөлд тэргүүн байр Ирвэсүүд баг, дэд байр Морьтонгууд баг, гутгаар байрыг Залуус баг Тэмцээний эрэгтэй шилдэг тоглогчоор Морьтонгууд багийн тамирчин Ш.Эрдэнэболд, эмэгтэй тоглогчоор Геронтологийн акулууд багийн

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			тамирчин Г.Одончимэг Дартсын төрөлд тэргүүн байр Морьтонгууд баг, дэд байр Ирвэсүүд баг, гутгаар байр Акулууд баг Теннисийн тэргүүн байр Эмэгтэй төрөлд Морьтон багийн Н. Мөнгөнсор, Эрэгтэй төрөлд Акулууд баг Э.Бямбасүрэн, Дэд байр эмэгтэй төрөлд Ирвэсүүд багийн Ш.Уранчимэг, эрэгтэй төрөлд Эрчис багийн А.Эрдэнэ-Очир, гутгаар байр эмэгтэй төрөлд Морьтон багийн Т. Дулмаа, эрэгтэй төрөлд Залуус баг М.Энхбаяр нар тус тус эзлэж багийн нийт дүнгээр тэргүүн байрт Морьтонгууд баг шалгарсан. 

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			 2. Геронтологийн үндэсний төв нь төвөөс тэтгэвэртээ гарч буй ахмад ажилтнууддаа дараалал харгалзахгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээг авах үнэмлэх олгодог. Тиймээс ахмад ажилтнууд жил бүр настны цогц тусламж үйлчилгээг авдаг.
5	Дэлхийн эмч нарын өдөр, Олон улсын сувилагч нарын өдөр ,Олон улсын эх баригчдын өдрийг аливаа хэлбэрээр баяр ёслолын шинжтэй тэмдэглэх, нийтээр архи, согтрууруулах ундаа хэрэглэх, албан зугаалга зохион байгуулахыг хориглоно.	Арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо	1.Эрүүл мэндийн сайдын “Тэмдэглэлт өдөр зохион байгуулах тухай” 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/85 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Геронтологийн үндэсний төв 2025 оны 04, 05 дугаар сард “Эмчээ сонсоё”, “Сувилагч, мэргэжилтнүүдээ сонсьё” уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Уулзалт арга хэмжээнд төвийн удирдлагын багийн бүрэлдэхүүн Төвийн захирал Р.Хишигжаргал, Дэд захирал М.Энхбаяр, СТА-ны дарга Н.Долгормаа, ЭМТҮЧАБА-ны дарга Г.Энхсүрэн, ЭТҮА-ны дарга А.Байгалмаа, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн С.Гантуяа, Уламжлалтын эмч Б.Ууганбаяр нар төвийн нийт 16 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 19 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад мэргэжилтэн, туслах ажилтнуудтай уулзаж, төвийн шинэ барилга ашиглалтад орохтой холбоотой үйл ажиллагааг өргөжүүлэх, настны эрүүл мэндийн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлын талаар, болон

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			цалин хөлс, ажилчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эерэг хандлагыг түгээх зорилгоор “Өөрчлөлт хэрэгтэй юу” сэдвээр чөлөөт яриа өрнүүлж сувилагч, тусгай мэргэжилтэн, бусад мэргэжилтэн, туслах ажилтнуудад тулгамдаж байгаа асуудал болон цаашид анхаарах, сайжруулах асуудлын талаар санал, хүсэлтийг нь сонсох ажиллагааг зохион байгууллаа.  

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			  2. Дэлхийн эмч нарын өдөр, Олон улсын сувилагч нарын өдөр ,Олон улсын эх баригчдын өдрийг тохиолдуулан Геронтологийн үндэсний төвөөс

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр урлагийн наадмыг зохион байгуулсан. Урлагийн наадмыг удирдамжийн дагуу мэндчилгээ, гоцлол дуу, бүжиг, хөгжим, шүлгийн 5 төрлөөр зохион байгуулж, төвийн ажилтнууд авьяас, ур чадвараа үзүүлсэн. Уралдааны мэндчилгээний төрлийг хамт олны оролцоо, идэвх, авьяас чадварыг оролцуулан үнэлэхэд Р.Даваадорж ахлагчтай “Гэгээн аялгуу” баг, гоцлол дуугаар сувилагч М.Отгонжаргал, бүжгээр эмч Д.Бямбасүрэн, хөгжмөөр эмч Г.Энхсүрэн, шүлгээр сувилагч Д.Отгонсүрэн нар тэргүүлсэн. Урлагийн наадамд М.Отгонжаргал ахлагчтай “Гэрэлт цох” баг тэргүүн, Д.Бямбасүрэн ахлагчтай “Мелоди” баг дэд, Р.Даваадорж ахлагчтай “Гэгээн аялгуу” баг гутгаар байруудыг тус тус амжилттай оролцлоо. Урлагийн наадмаар төвийн ажилтнуудын авьяас чадварыг нээн тодруулах, байгууллагаа таниулан сурталчлах, хамт олонч, нөхөрсөг байдлыг нэмэгдүүлэх, урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэх ач холбогдолтой арга хэмжээ болсон.  

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
			 

ТАЙЛАН БИЧСЭН:

Ч.ӨНӨРЦЭЦЭГ /ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР/

ТАЙЛАН ХЯНАСАН:

Н.ДОЛГОРМАА /ЗАХИРГАА,СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ДАРГА/